

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

СУЛ ОРОН ТООНЫ ЗАР

2024.11.07

Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг үндэслэн Үндэсний аудитын газарт Тамгын газрын “Хуулийн хэлтсийн дарга”, “Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн шинжээч”, “Сургалт судалгааны хэлтсийн дарга”, “Мэдээллийн технологийн нэгдсэн төвийн шинжээч”, Нийслэл дэх Төрийн аудитын газарт “Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн аудитор”-ийн албан тушаалын сул орон тоог зарлаж байна.

Нэг., Үндэсний аудитын газрын “Хуулийн хэлтсийн дарга”, “Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн шинжээч”, “Сургалт судалгааны хэлтсийн дарга”, “Систем хөгжүүлэгч шинжээч”, Нийслэл дэх Төрийн аудитын газрын “Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн аудиторын албан тушаал

1. Албан тушаалд тавигдах ерөнхий шаардлага

- Монгол Улсын иргэн байх;
- Дээд боловсролтой байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх (эрэгтэй);
- Төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагч эсхүл төрийн жинхэнэ албаны нөөцөд байх;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан байх;

2. Албан тушаал тавих тусгай шаардлага

2.1. “Хуулийн хэлтсийн дарга”-ын албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	-Эрх зүй /042/;
Мэргэшил	- Ахлах түшмэл эсхүл түүнтэй адилтгах мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх, -Мэргэшсэн хуульч байх, -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах талаар суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.(АЗ сертификат)
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс төрийн аудитын ахлах түшээ эсхүл төрийн захиргааны ахлах түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.

2.2. “Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах хэлтсийн шинжээч”-ийн албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	-Нийгмийн шинжлэх ухаан, Мэдээлэл, сэтгүүл зүй - /0311-0313, 031401, 031402, 032101/;
Мэргэшил	-Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх.

Туршлага	-Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.
-----------------	---

2.3.“Сургалт судалгааны хэлтсийн дарга”-ын албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Менежмент ба удирдахуй /041301-041303/ -Боловсрол /0111, 0114, 011401, 011402, 011403, 011405/ -Эдийн засаг /0311/ -Нягтлан бодох бүртгэл /041101/ -Санхүү /041201/ -Математик, статистик /054/ -Социологи /031402/ -Маркетинг /041401/.
Мэргэшил	- Ахлах түшмэл эсхүл түүнтэй адилтгах мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх, -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах талаар суурь мэдлэг олгох сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх.(А3 сертификат)
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс төрийн аудитын ахлах түшээ эсхүл төрийн захиргааны ахлах түшмэл болон түүнтэй адилтгах ангиллын албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.

2.4. “Мэдээллийн технологийн нэгдсэн төвийн “Систем хөгжүүлэгч шинжээч”-ийн албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	- Өгөгдлийн ухаан /061204/ - Өгөгдлийн сангийн загварчлал /061205/ - Программ хангамж /061302/ - Мэдээллийн систем /061303/ - Мэдээллийн технологи /061304/ - IoT/Зүйлсийн интернэт/технологи /061901/ Хиймэл оюун ухаан /061902/
Мэргэшил	-Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх.
Туршлага	- Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх; Системийн хөгжүүлэлт болон өгөгдлийн сан дээр ажиллаж байсан туршлагатай байх.

2.5.“Мэдээллийн технологийн нэгдсэн төвийн “Техник хангамж хариуцсан шинжээч”-ийн албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	- Хэрэглээний программ / 061101/ - Компьютерын сүлжээ /061201/ - Компьютерын ухаан /061301/ -Мэдээллийн технологи /061304/.
Мэргэшил	-Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх.
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.

2.6.“Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн аудитор”-ын албан тушаалд тавигдах тусгай шаардлага

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	Зам, гүүрийн байгууламжийн инженер /073210/ Барилгын техник, технологи //073204/
Мэргэшил	-Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх.
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.

Хоёр. Шалгалт өгөхийг хүссэн албан хаагч бүртгүүлэхдээ дор дурдсан бичиг баримтыг бүрэн ирүүлнэ. Үүнд:

- Шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн хуулбар (диплом) Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар эсхүл Цахим лавлагаа (“e-mongolia”- аас татан авах);
- “4 х 6”-ийн хэмжээний цээж зураг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт.
- Төрийн албанд ажилласан жил тооцох зорилгоор албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia–аас татан авах) ;
- Төрийн жинхэнэ албан хаагч бол сүүлийн 1 жилийн дотор ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл хүлээгээгүйг нотлох бичиг баримт;

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

Албан тушаалын орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад оролцох албан хаагч, иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг 2024 оны 11 дугаар сарын 07-ны өдрийн 09:00 цагаас 2024 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн 12:00 цаг хүртэл Үндэсний аудитын газрын 306 тоотод хүлээн авна.

Дөрөв. Хүсэлт ирүүлсэн албан хаагчдад мэдээлэл хүргэх:

Орон тоо нөхөх тусгай шалгалт өгөх хүсэлт ирүүлсэн албан хаагч, иргэний бичиг баримтыг хянаж, албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан эсэх тухай мэдээлэл болон тусгай шалгалтыг зохион байгуулах хугацааг албан хаагчийн цахим хаягаар мэдэгдэнэ.

Холбоо барих утасны дугаар
Үндэсний аудитын газар: 51-261585

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР